



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

### Олон улсын эксперт багштай сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/525 дугаар захирамж, нийслэлийн Засаг даргын 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 4.1.7, 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласны хүрээнд жуулчдыг хүлээн авах бэлтгэлийг хангуулах, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аялал жуулчлал өндөр хөгжсөн орноос эксперт багш нарыг урьж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны үйлчилгээний байгууллагын удирдлага, ажилчдад зориулсан сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах зардал 20,560,000 (Хорин сая таван зуун жаран мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Уянга)-д зөвшөөрсүгэй.

3. Сургалт зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2024 оны 05 сарын 28 өдрийн  
А11 дугаар тушаалын хавсралт



ОЛОН УЛСЫН ЭКСПЕРТ БАГШТАЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СУРГАЛТЫН ТӨСӨВ

Хүснэгт №1

Д/д	Задаргаа	Нэгж үнэ	Хүний тоо	Өдөр	Нийт
1	Багшийн ажлын хөлс	412,500	2	4 өдөр 16 цаг	3,200,000
2	Сертификат хэвлүүлэх зардал	7,000	100 ш	-	700,000
3	Зочид буудлын зардал	270,000	-	5	1,350,000
4	Зочид буудлын зардал	270,000	-	3	810,000
5	Тосох үдэх үйлчилгээний зардал		-	6	1,000,000
6	Хурлын танхимын түрээсийн төлбөр	1,750,000	-	2	3,500,000
Нийт дүн					20,560,000